



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 1/29

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар захирамж, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны 04 дүгээр хуралдааны 08 дугаар “Сумын 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээнүүдийн 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадварыг нэмэгдүүлэх “Энтрепренершип”-ийн боловсрол олгох төсөлд 3 дугаар сургуулийн Ж.Баярцэцэг удирдагч багштай “Fabric painting”, “Нэхмэл гар урлал” төслүүдэд 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. “Fabric painting”, “Нэхмэл гар урлал” төслүүдэд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тус төсөлд зарцуулагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг хөтөлбөрт суурилсан арга хэмжээний зардлаас олгохыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА



Сумын Засаг даргын 2025 оны
02-р сарын 17-ны өдрийн
1129 дугаар захирамжийн хавсралт

Төслийн жагсаалт

№	Төслийн нэр	Хариуцсан багш	Регистр	Банк	Данс	Үнэ	Нийт үнэ
1	fabric painting	Ж.Баярцэцэг	3B90080609	ХААН	5312599649	2.500.000	2.500.000
2	Нэхмэл гар урлал	Ж.Баярцэцэг	3B90080609	ХААН	5312599649	2.500.000	2.500.000
3	Нийт үнэ						5.000.000